



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/41

Мандалговь

Дотуур байрны дотоод журам
батлах тухай


Дундговь аймаг дахь Политехник коллежийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймаг дахь Политехник коллежийн Дотуур байрны дотоод журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Дотуур байрны багш, ажилтан, суралцагчдад үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод чанарын баталгаажилт, статистик мэдээ хариуцсан ахлах ажилтан (О.Уртнасан)-д даалгасугай.

ЗАХИРАЛ  Ю.ЦОЛМОН



Захирлын 2022 оны 09 дүгээр сарын 29
өдрийн А/Н/Т тоот тушаалын хавсралт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН

ДОТУУР БАЙРНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмыг Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Дундговь аймаг дахь Политехник коллежийн хөдөлмөрийн дотоод журам, дүрэм болон Хүүхэд хамгааллын бодлого зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн боловсруулав.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 Энэхүү журмын зорилго нь Дундговь аймаг дахь Политехник коллеж-д /Цаашид сургууль гэх/ суралцаж буй суралцагчдын дотуур байранд амьдрах, сурч хөгжих боломжийг бүрдүүлэх, дотуур байрны багш, ажилтан, суралцагч, асран хамгаалагчдын хоорондын харилцааг зохицуулах, нийтлэг дэг журмыг сахиулахад оршино.

Гурав. Оршин суух суралцагчийн эрх, үүрэг

- 3.1 Суралцагч дотуур байранд амьдрах хүсэлтээ албан ёсоор дотуур байрны багшид гаргана. Дотуур байранд оршин суух суралцагч нь эцэг эх, асран хамгаалагчийн хамт ирж дотуур байрны журам, оршин суух гэрээний зүйл заалттай танилцан хүлээн зөвшөөрсөн бол сургууль, суралцагч, асран хамгаалагчийн гурвалсан гэрээ байгуулснаар дотуур байранд амьдрах эрх үүснэ. Энэхүү гэрээ болон дотуур байрны журмыг мөрдлөг болгон амьдарна.
- 3.2 Дотуур байранд нийтийн эзэмшлийн талбай болон өрөө тасалгааг зүй зохистой ашиглаж, цэвэрлэгээ үйлчилгээг хуваарийн дагуу чанартай хийнэ.
- 3.3 Мэргэжлийн байгууллагаас гаргасан эрүүл мэнд, эрүүл ахуйн заавар зөвлөмжийг мөрдөж, өрөөний болон хувийн ариун цэврийг тогтмол сахиж, эрүүл мэнд, амь насаа хамгаална. Ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ээлжинд ажиллаж буй дотуур байрны багш, ажилтанд үнэн зөв мэдээлэх, шаардлагатай тусламж авах эрх, үүрэгтэй.
- 3.4 Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор амны хаалт тогтмол зүүх, гарын ариун цэврийг сахих, хоолойгоо зайлах, нүд ам хамартаа гараа хүргэхгүй байх, нийтийн эзэмшлийн газар, гудамж талбайд нус цэр, шүлсээ ил задгай хаяхгүй байх, бусадтай хүнсний бүтээгдэхүүн хувааж идэхгүй байх, олон хүн цугларсан газраар явахгүй байх үүрэгтэй.
- 3.5 Тасагтаа тохижилт хийж ая тухтай орчин бүрдүүлэхэд санаачилгатай ажиллана. Дотуур байрны эд зүйл эвдэж сүйтгэсэн бол буруутай этгээд нөхөн төлж хохирлыг барагдуулна.
- 3.6 Байрны багш, ажилтан, байрны сурагчдын зөвлөлтэй зөв зохистой харилцаж, тэдний тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлэх, зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох үүрэгтэй.
- 3.7 Хичээл таслах, дотуур байр, нийтийн эзэмшлийн газарт согтууруулах ундаа уух, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах, хог хаях, хөгжим чанга тавих, орилж хашгирах, зорилгогүй сэлгүүцэх, бэлгийн харилцаанд орох, бусдыг садар

самуунд уруу татах, сургуулиас олгосон эд хөрөнгийг эвдэх, бусдын эд зүйлийг хулгайлах, цонхоор гадны хүн оруулах, гаргах, хонуулах, чөлөө зөвшөөрөлгүй гадуур хонох зэргээр зүй зохисгүй үйлдэл гаргахыг хатуу хориглоно.

Энэ төрлийн асуудал үүсгэсэн тохиолдолд дотуур байрнаас гаргах арга хэмжээ авч эцэг эх, асран хамгаалагчид илтгэх хуудсын хамт хүлээлгэж өгнө.

- 3.8 Галын аюулгүй байдлыг чанд мөрдөн сахих ба зориулалтын бусаар элдэв цахилгаан хэрэгсэл ашиглахыг хориглоно.
- 3.9 Суралцагч албан ёсны чөлөө зөвшөөрөлтэйгөөр гачигдал гарах, дадлагын хичээлд хамрагдах, цалинтай ажил хийх, бусад цаг үеийн ажилд дайчлагдан ажиллаж байгаа бол тухайн өдрийн ээлжинд ажиллаж буй дотуур байрны багшийг хариуцан ажиллаж буй хүмүүстэйгээ холбоо бариулж үнэн зөв мэдээлсний үндсэн дээр шөнийн 22.00 цагаас өмнө дотуур байранд ирж бүртгүүлсэн байна.
Дотуур байрны багш суралцагчийн явсан шалтгаан, ирсэн цагийг рапортод тэмдэглэнэ.
- 3.10 Өөрийн хүсэлтээр дотуур байрнаас гарч болох ба эцэг эх, асран хамгаалагчийн хамт ирж гэрээг цуцлан тооцоогүйн баталгааг гарган өгч байрнаас гарна. Энэ тохиолдолд дотуур байрны багш тухайн суралцагчийн анги удирдсан багшид заавал мэдээлнэ.
- 3.11 Дотуур байрны үйл ажиллагаа, үйлчилгээний талаар санал, хүсэлтийг эцэг эх, асран хамгаалагч, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, сургуулийн захиргаанд хүргүүлэх, шийдвэрлүүлэх эрхтэй.
- 3.12 Энэхүү гэрээг зөрчин дотуур байрнаас хасагдсан тохиолдолд дотуур байранд дахин оршин суух эрхгүй болно.

Дөрөв. Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн эрх үүрэг

- 4.1 Хүүхдээ дотуур байранд оруулах хүсэлтээ байрны багшид албан ёсоор гаргаж, дотуур байрны журам, оршин суух гэрээний зүйл заалттай танилцан хүлээн зөвшөөрсөн бол гурвалсан гэрээ байгуулна.
- 4.2 Дотуур байранд орохдоо шаардлагатай бичиг баримт, хичээлийн хэрэгсэл /ном дэвтэр, үзэг харандаа, цүнх/, хөнжил, цагаан хэрэглэл, ахуйн болон ариун цэврийн хэрэглэл, гэрийн шаахай, цэвэрлэгээний бодис материал, хогийн шүүр хутгуур, хувцас угаах түмпэн зэргийг бэлтгэж, дотуур байрны багш ажилтнуудад хянуулж орно.
- 4.3 Хүүхдийнхээ амьдарч буй өрөө тасалгааг хамт амьдарч буй хүүхдүүдийн асран хамгаалагчидтай хамтран тохижуулах, дотуур байранд ая тухтай амьдрах, сурч хөгжих шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.4 Хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө зөвшөөрлийг албан ёсоор авна. Хичээл сургалтын үеийн чөлөөг АУБ-ийн зөвшөөрөлтэйгөөр сургалтын албанаас /хавсралт-1/, амралтын өдрийн чөлөөг дотуур байрны багшаас /хавсралт-2/ авна. Хүүхдийг дотуур байрны багш-эцэг эх асран хамгаалагч гараас гарт хүлээлцэнэ.
- 4.5 Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэдээ байнга анхаарал, халамж тавьж, дотуур байрны багш, ажилтнуудтай тогтмол харилцаа холбоотой байх, санал солилцох, хамтран ажиллах эрх, үүрэгтэй.
- 4.6 Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн бол багшид нэн даруй мэдэгдэнэ.
- 4.7 Хүүхдээ эрүүл мэндийн даатгалд хамруулж, биеийн байдал архаг хууч, олдмол өвчин, гаж буруу зуршил, урьд өмнө хэв журмын зөрчил гаргаж байсан эсэх, хорт

дадал зуршил /архи тамхи, мансууруулах бодис/-д өртөх магадлалтай бол нуун дарагдуулахгүй мэдээлж, анги удирдсан багш, байрны багш, сургуулийн захиргаанд танилцуулж хамтран ажиллах эрх, үүрэгтэй.

- 4.8 Хүүхдийнхээ сурлага хүмүүжил, хөгжил, төлөвшилд байнга анхаарч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн, сургуулийн захиргаанаас тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлэн, хамтран ажиллана.
- 4.9 Эцэг эх, асран хамгаалагч нь нь дотуур байрны журам, гэрээ болон бусад холбогдох хууль, дүрэм журам, ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө.
- 4.10 Хэрэв хүүхдээ дотуур байрнаас гаргах бол дотуур байрны багштай гэрээг албан ёсоор цуцлан хүүхдээ хүлээн авна.

Тав. Сургуулийн захиргааны эрх үүрэг

- 5.1 Дотуур байрны багш, ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний шаардлагыг сахиулж ажиллана.
- 5.2 Суралцагчдыг дотуур байранд оршин суух нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 5.3 Суралцагчтай гурвалсан гэрээ байгуулах ба гэрээг зөрчсөн суралцагчийн асуудлыг тодруулан улмаар гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 5.4 Ажил үүргээ гүйцэтгэж буй ажилтнуудын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэвийн нөхцөлийг хангана.
- 5.5 Дотуур байранд суух суралцагчдад нийтээр эзэмших өрөө, ор, ширээ, сандал зэрэг эд хөрөнгө олгож цэвэр ус, дулаан, цахилгаанаар ханган эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 5.6 Дотуур байранд оршин сууж буй суралцагч, суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдын санал хүсэлтийг хүлээн авч хамтран ажиллана.
- 5.7 Дотуур байрны багш, ажилтнуудын хөгжил, суралцагчдын хүмүүжил төлөвшилд анхаарч тасралгүй үйл ажиллагаанд хамруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 5.8 Байрны дотоод журмыг суралцагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 5.9 Хоолны чанар, хэмжээ, илчлэг байдалд хяналт тавьж, эрүүл аюулгүй хүнсээр хангаж ажиллана.
- 5.10 Дотуур байрны үйл ажиллагааг хэвийн хангаж явуулахад багш, ажилтнуудад дэмжлэг үзүүлж, олон нийтийн гүүр болж холбон зуучилж ажиллах үүрэгтэй.

Зургаа. Дотуур байрны багш, ажилтнуудын эрх, үүрэг

- 6.1 Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.
- 6.2 Багш, ажилтнууд нь цаг үеийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр санаачилгатай хандана.
- 6.3 Багш, ажилтнууд жижүүрийг батлагдсан хуваарийн дагуу хийж, ээлжийг 10 минутын өмнө ирж хүлээлцэх бөгөөд жижүүрийн хугацаанд ажлын байраа орхихыг хатуу хориглоно.
- 6.4 Багш, ажилтнууд хариуцсан өрөө, тасалгаа, талбайн цэвэр цэмцгэр, тав тухтай байдал, эд хогшлын ашиглалтад байнга анхаарч, шаардлагатай засвар үйлчилгээг цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ.
- 6.5 Ээлжтэй байх хугацаандаа байрны гадна, дотор орчинд цахилгаан, гал түймэр, цэвэр усны алдагдал, хулгай халдлага зэргээс урьдчилан сэргийлж сэрэмжлэх, суралцагчдын эрүүл, аюулгүй байдалд онцгойлон анхаарч гэмт хэрэг зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж хяналт тавьж ажиллана.

- 6.6 Дээрх заалт зөрчигдсөн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авах, холбогдох хүмүүсээс тусламж дэмжлэг авч хамтран ажиллах, тухайн асуудлыг таслан зогсоож сургуулийн захиргаанд мэдээллэх, жижүүрийн тэмдэглэлд бичиж нотолгоожуулах үүрэгтэй.
- 6.7 Дотуур байрны багш нь суралцагчдад сэтгэл зүйн, үйлийн, материаллаг орчинг цогцоор нь бүрдүүлж тэдний эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийг хангасан олон төрлийн үйл ажиллагааг хүмүүжлийн эерэг аргыг ашиглан, төлөвлөн зохион байгуулж үр дүнг тооцон нийтэд мэдээллэх үүрэгтэй.
- 6.8 Багш, ажилтнууд нь ээлжтэй байх хугацаандаа эрүүл мэнд, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Мөн дулааны улирал /9-10, 4-5 сар/-д 20:00, хүйтний улирал /11-3 сар/-д 19:00 цагт дотуур байрны хаалгыг барьж суралцагчдад хэв журмыг сахиулах эрх, үүрэгтэй.
- 6.9 Багш, ажилтнууд суралцагчдыг энэхүү журам болон оршин суух гэрээний зүйл заалтыг биелүүлэхэд зөвлөн туслах, зүй ёсны шаардлага тавих эрх, үүрэгтэй.
- 6.10 Багш, ажилтнууд нь үлгэр жишээ оршин суудаг суралцагчдыг урамшуулах, алдаршуулах, дотуур байрны үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг санаачлан зохион байгуулах эрх, үүрэгтэй.
- 6.11 Дотуур байранд оршин сууж буй суралцагчдын бүртгэл, судалгааг цаг тухай бүрт гарган холбогдох хүмүүст, мөн суралцагчтай холбоотой мэдээллийг анги удирдсан багш нарт хүргэж хамтран ажиллах эрх, үүрэгтэй.
- 6.12 Дотуур байрны багш, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд саад бэрхшээл тохиолдвол санал хүсэлтээ сургуулийн захиргаанд хандан шийдвэрлүүлэх, мэргэжлийн хүмүүстэй албан шугамаар харилцаж тусламж, дэмжлэг авах эрх, үүрэгтэй.

Долоо. Дотуур байрны суралцагчдын зөвлөлийн эрх, үүрэг

- 7.1 Дотуур байрны суралцагчдын саналаар зөвлөлийг байгуулна.
- 7.2 Дотуур байрны суралцагчдын хамгаалуулах, хөгжих, оролцох эрхийг хангахад чиглэсэн зохион байгуулж буй бүхий л ажлыг дэмжин туслах үүрэгтэй.
- 7.3 Зөвлөлийн гишүүд өөрсдийн болон бусад суралцагчдын санал хүсэлтийг авч анги удирдсан багш, нийгмийн ажилтан, сургалтын алба, сургуулийн захиргаанд уламжлах, шийдвэрлүүлэх эрх, үүрэгтэй.
- 7.4 Дотуур байрны суралцагчдын эрх ашиг нь хөндөгдсөн, хүчирхийллийн шинж илэрсэн тохиолдолд дотуур байрны багш, ажилтан, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, бусад холбогдох хүмүүс, мэргэжлийн байгууллагад хандан асуудлыг шийдвэрлүүлэх, эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.
- 7.5 Дотуур байрны суралцагчдын дунд чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх, багш, эцэг эх асран хамгаалагчид, суралцагчдын харилцаанд ахиц дэвшил гарахуйц шинэлэг, төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулж байрны суралцагчдыг бүрэн хамруулж татан оролцуулах эрх, үүрэгтэй.
- 7.6 Зөвлөлийн гишүүд дүрэмт хувцас, лого, туг, энгэрийн тэмдэг зэргийг санаачлан хийж үйл ажиллагаандаа ашиглах, сургуулийн захиргаанаас дэмжлэг авах, бусад суралцагчид, багш, эцэг эх асран хамгаалагчид, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчлан таниулах эрх, үүрэгтэй.